

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”

АУДИТЫН КОД: ДУА-2021/36-11-ШТА-ГА

Дундговь дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
үүргийг түр орлон гүйцэтгэгч
Р.Мөнхтогтох Утас: 70592439,

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 7059-2225

Ахлах аудитор Д.Ихбаяр
Аудитор Д.Должинсүрэн
Утас: 7059-2208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Агуулга	2
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгс	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
	Дүрслэлийн товъёг	6-7
	<u>Бүлэг 1. Сонгууль зохион байгуулах зардлыг хууль журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна.</u>	
Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мөнхтогтох	1.1 Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.	8-10
Аудитын менежер Х.Наранцацрал	1.2 Сонгууль зохион байгуулах зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч хэмнэлтгүй зарцуулжээ.	10-12
	<u>Бүлэг 2. Сонгууль зохион байгуулах зардлыг журмын дагуу тайлагнаж, хяналт тавьж ажигласан байна.</u>	
Ахлах аудитор Д.Ихбаяр	2.1 Сонгуулийн зардлын бүртгэлийг журмын дагуу хөтөлж, тайлагнасан байна.	13
Аудитор Д.Должинсүрэн	2.2 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.	13
	Дүгнэлт	14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал	14
	Тайлан баталгаажуулсан тушаал	15
	Тайлангийн хавсралтууд	16-23
ХАЯГ:		
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот		
2021 оны 7 дугаар сар		

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
СХ	Сонгуулийн хороо
УИХ	Улсын Их Хурал
УБЕГ	Улсын бүртгэлийн Ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУ	Монгол Улс
УСНББОУС	Улсын Секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
МТБ	Мэдээлэл технологийн баг
САС	Сонгуулийн автоматжуулах систем

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

“Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэл”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Сонгууль зохион байгуулах зардлыг хууль журмын дагуу хуваарилж, үр дүнтэй зарцуулсан эсэх;
- ✓ Сонгууль зохион байгуулах зардал хууль журамд нийцүүлэн хяналт тавьж ажилласан эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль;
- ✓ Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль;
- ✓ СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”
- ✓ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- ✓ Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;
- ✓ Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн Сонгуулийн хороо, сумдын Сонгуулийн хороод, Улсын бүртгэлийн хэлтэс, Дундговь аймаг дахь Цагдаагийн газар болон бусад холбогдох байгууллагуудыг хамруулна.

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-

Аудитын арга зүй:

5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд шалгах хуудсаар нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн, ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Ч.Оюунтүлхүүр, ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Б.Гантуяа, Т.Оюун-Эрдэнэ, Ж.Угтахбаяр, аудитор Л.Уранбилэг, нягтлан бодогч Б.Энх-Хорлоо нар гүйцэтгэлийн үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын тайлагналын үе шатны ажлыг ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн нар 2021 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс 2021 оны 07 дүгээр сарын 09-ний өдрийг дуустал хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Аудитаар материаллаг байдлыг 4.3 сая төгрөгөөр тооцсон.

Аудитаар нийт 69.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж аудитын явцад 68.5 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 0.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, 0.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Сонгуулийн хороо

СЕХ нь Дундговь аймагт аймаг сумын нийт 16 сонгуулийн хороо, 52 хэсгийн хороог, 631 ажилтантайгаар зохион байгуулсан байна. / Хавсралт № 1/

Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардалд улсын төсвөөс олгох санхүүжилтээс Сонгуулийн Ерөнхий Хороо Дундговь аймгийн сонгуулийн хороонд 428.0 сая төгрөгийг хуваарилсан байна.

Дундговь аймагт хуваарилагдсан нийт төсвийн 7.6 хувь буюу 32.6 сая төгрөгийг аймгийн Сонгуулийн хороонд, 395.4 сая төгрөг буюу 92.4 хувийг сумдын сонгуулийн хороонд тус тус хуваарилсан байна.

Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газар

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд 50.7 сая төгрөг, Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын төсөвт 11.8 сая төгрөгийг хуваарилж, улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁГ

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Сонгуулийн зардлын санхүүжилт	8

График товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдаж ирсэн зардлын эзлэх хувь	8

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын бүртгэлийн ажилтны тоо болон томилолтын хоногийн зөрүү	10
Хүснэгт 2	Буцаан төвлөрүүлсэн дүн	11
Хүснэгт 3	Ковид -2019 цар тахалтай холбоотой ишинээр нэмэгдэж ажилласан хүний тоо, зарцуулсан зардал	

Хавсралтын товъёг


<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хавсралт 1</i>	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн аймаг, сумын хэсгийн хороонд ажилласан ажилчдын судалгаа</i>	<i>18</i>
<i>Хавсралт 2</i>	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төсвийн хуваарь</i>	<i>19</i>
<i>Хавсралт 3</i>	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн төсвийн зардлын нэгтгэл</i>	<i>20-21</i>
<i>Хавсралт 4</i>	<i>МҮЕС-ийн сонгуулийн үр дүнд төсвийн байгууллагад орлогодож бүртгэлд авсан хөрөнгийн жагсаалт</i>	<i>22-23</i>
<i>Хавсралт 5</i>	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулиар улсын бүртгэлийн хэлтсийн ажилтнуудад олгосон урамшуулал</i>	<i>24</i>



БҮЛЭГ 1. Сонгууль зохион байгуулах зардлыг хууль журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна.

1.1 Сонгуулийн хороодод зардлын төсвийг журмын дагуу хуваарилсан байна.

Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуульд СЕХ-оос Дундговь аймгийн Сонгуулийн хороонд олгосон нийт 428.0 сая төгрөгийн санхүүжилтийг 4 хуваан олгосон бөгөөд эхний санхүүжилт 79.4 сая төгрөгөөс 63.2 сая, 2 дахь санхүүжилт 37.3 сая төгрөгөөс 23.0 сая, 3 дахь санхүүжилт 310.1 сая төгрөгөөс 301.4 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороодод, 4 дэх санхүүжилт 1.3 сая төгрөг болон үлдэгдэл 31.3 сая төгрөгийг аймгийн сонгуулийн хороонд тус тус хуваарилсан байна. /Зураг №1/



Дундговь аймгийн Сонгуулийн хороог 15 сумын Сонгуулийн хороо, 52 хэсгийн хороотойгоор зохион байгуулж нийт 428.0 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилж олгосон байна.

Аймгийн сонгуулийн хорооноос сумдад хуваарилсан нийт 17 нэр төрлийн зардлын төсвийг СЕХ-ны ажлын албаны 2021 оны 3/71, 3/103, 3/124 тоот бичгийн хавсралтаар батлагдсан аргачлалаар давтан тооцож үзэхэд 1 нэр төрлийн зардлын төсвийн хуваарилалтаас бусад зардлыг аргачлалын дагуу хуваарилж олгосон байна.

Сонгуулийн хэсгийн хороодод хуваарилсан унааны зардал: Сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодод сонгууль зохион байгуулах унааны зардлыг хуваарилахдаа газар нутгийн байршил хэмжээ, онцлогийг харгалзан тооцоолол хийлгүй, зөвхөн хэсгийн тоонд үндэслэн хуваарилсан байна. Жишээ нь: Дэлгэрцогт сумын газар нутгийн хэмжээг Өлзийт сумын газар нутгийн хэмжээтэй харьцуулахад 1,292.8 мянган га-гаар илүү боловч сонгууль зохион байгуулах хэсгийн хорооны тооноос хамаарч зарцуулах шатахуун ижил хэмжээтэй хуваарилагдсан байна. /Хавсралт №2/ Мөн аймаг, сумын төвийн болон хөдөөгийн хэсгийн хорооны унааны зардлыг онцлогийг нь харгалзахгүй хуваарилсан байна.

Энэ нь сонгуулийн зардлыг зарим хэсгийн хороод хэтэрхий үрэлгэн зарцуулах, зарим хэсэгт төсөв нь хүрэлцэхгүй дутагдан, зориулалт бус зарцуулалт гаргах сөрөг талтай байна.

Цаашид аймгийн сонгуулийн хорооноос шатахууны зардлыг сумдын газар нутгийн хэмжээ, сонгогчийн тоо бусад үзүүлэлтүүдийг харгалзан хуваарилах зарчмыг баримталж, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй үр ашигтай зарцуулагдах боломжийг нь олгоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

Улсын бүртгэлийн хэлтэс

Сонгуулийн зардлын төсвийг хуваарилахдаа бодит нөхцөл байдалтай уялдуулж хуваарилаагүй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны А/176 тоот “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” тушаалаар Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 50.7 сая төгрөгийн санхүүжилтийг баталж, олгосон байна.

УБЕГ-ын дээрх тушаалын 1 дүгээр хавсралтад итгэмжлэгдсэн ажилтныг 52 байхаар баталсан боловч 4 дүгээр хавсралтад сургалт зохион байгуулах зардлын төсөвт итгэмжлэгдсэн ажилтныг 50, томилолтыг 2 хоногоор тооцож, 9.1 сая төгрөг төсөвлөснөөр Сайнцагаан сумын 9 итгэмжлэгдсэн ажилтны албан томилолт, унааны зардлын 1.3 сая төгрөгийг илүү төлөвлөсөн байна. /Хүснэгт 1/

Хүснэгт 1 Бүртгэлийн ажилтны тоо болон томилолтын хоногийн зөрүү

д/д	Зардлын нэр	Ажиллагсдын тоо, хоног			Зөрүү	
		Батлагдсан тоо		Гүйцэтгэл	Тоо	/сая төгрөг/
1	Сургалт зохион байгуулах /Томилолт, унаа/	Итгэмжлэгдсэн ажилтан	50	43	7	1.3
		Томилолтын хоног	2	2	-	
2	Техник хэрэгсэл тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах	Ажиллах хүний тоо	4	6	(2)	0.3
		Томилолтын хоног	4	2	2	
3	Шуурхай багийн зардал	Ажиллах хүний тоо	3	8	(5)	
	Нийт дүн		67.5	63.0	2	1.6

Техник хэрэгсэл тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах зардлын томилолтын төсвийг 4 хоног, ажилтны тоог 4 хүнээр тооцож баталсан ч гүйцэтгэлээр 2 хоног, техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангахад 6 ажилтан /Цагдаа-1, Тагнуул-1, УБХ-1, жолооч-2/ ажиллах шаардлага гардаг тул 2 хүний томилолт 0.3 сая төгрөгийг батлагдсан төсөвт багтаан зарцуулжээ.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын А/07 тоот тушаалаар шуурхай багийн ажилтныг 8 байхаар томилсон боловч “Шуурхай багийн зардал” /шуудан холбоо, хоол, унаа/-ын төсвийг 3 ажилтнаар баталж, гүйцэтгэлээр 8 ажилтанд олгосон байна.

Дээрх асуудлууд нь томилолтын хоног болон ажиллах хүний тоог бодит нөхцөл байдалд уялдуулж төлөвлөөгүй, төсвийг илүү, дутуу тооцож баталсан, төсвийг батлахдаа зардлын эдийн засгийн ангиллыг тодорхой заагаагүй зэрэгтэй холбоотой байна.

Эдгээр нь батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулах, төсвийг зориулалт бусаар зарцуулах зэрэг эрсдэлийг бий болгож байна /Хүснэгт № 1/

Мөн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардалд, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг суулган өгч, тооцсон урамшууллаас суутгасан байна. Харин аймгийн сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардалд байгууллагаас төлөх НДШ-ийг суулгаж өгөлгүй, харилцан адилгүй зардлыг төлөвлөсөн байна. Энэ нь сонгуулийн зардлыг нэгдсэн бодлогоор хангаагүйг харуулж байна.

Иймд сонгуулийн зардлын төсвийг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж хуваарилан, сонгуулийн зардлыг нэгдсэн бодлогоор хангаж ажиллах талаар УАГ-аар дамжуулан холбогдох дээд шатны байгууллагад уламжилж байна.

1.2 Сонгууль зохион байгуулах зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч хэмнэлтгүй зарцуулжээ.

Хүснэгт №2

Сонгууль зохион байгуулах зардлын төсөв нийт 428.0 сая төгрөг, гүйцэтгэл 413.6 сая төгрөг, 14.4 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнаж, үлдэгдлийг СЕХ-нд төвлөрүүлсэн байна. Буцаан төвлөрүүлсэн дүнг сонгуулийн хороо тус бүрээр харууллаа. /Хүснэгт №2/

Буцаан төвлөрүүлсэн зардлыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл: МТБ, даамлын сургалтын зардал 8.1 сая, саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал 1.7 сая, томилолт болон болзошгүй зардал тус бүр 1.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд Ковид-19 цар тахлын тархалт нэмэгдсэнтэй холбоотой МТБ, даамлын сургалт зохион байгуулагдаагүйгээс шалтгаалсан байна. /Хавсралт № 3/

Аймгийн сонгуулийн хороо СЕХ-ны 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.9¹-т заасан хугацаанд сонгуулийн зардлын тайланг СЕХ-нд хүргүүлсэн байна.

№	Сонгуулийн хорооны нэр /Сум/	Буцаан төвлөрүүлсэн дүн /сая төг/
1	АСХороо	3.7
2	Сайнцагаан	0.9
3	Адаацаг	0.9
4	Баянжаргалан	0.3
5	Говь-Угтаал	0.5
6	Гурвансайхан	0.5
7	Дэлгэрхангай	1.2
8	Дэлгэрцогт	1.1
9	Дэрэн	0.5
10	Луус	1.1
11	Өлзийт	0.6
12	Өндөршил	0.5
13	Сайхан-Овоо	0.7
14	Хулд	0.7
15	Цагаандэлгэр	0.4
16	Эрдэнэдалай	0.9
Дүн		14.4

Тус аудитаар нийт 68.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 16.8% байна. Тухайлбал батлагдсан төсвийг зориулалт бусаар болон хэтрүүлэн зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, худалдан авсан хөрөнгийг шууд зардлаар тайлагнасан, санхүүгийн тайланд санхүүжилтийг дутуу

¹ Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийг зардлын үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлнэ.

болон нэр төрлөөр тайлагнаагүй зэрэг зөрчлүүд илэрч, аудитын явцад 0.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 68.5 сая төгрөгийн зөрчлийг залруулжээ.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16.5.5², Сонгуулийн тухай хуулийн 32.1.6³, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1⁴, 5.1.4-т /үнэн зөв байх/, Сонгуулийн Ерөнхий Хорооны 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.2⁵, 3.8⁶-т заасныг тус тус зөрчсөн байна.

Хүснэгт 3

№	Сумдын нэр	Ковид -19 цар тахалтай холбоотой шинээр нэмэгдэж ажилласан хүний тоо, зарцуулсан зардал /мянган төгрөг/			
		Хүний тоо	Олгосон урамшуулал	Хоолны зардал	Нийт
1	Дэлгэрхангай	2	840		840
2	Луус	1	420		420
3	Өндөршил	1	420		420
4	Сайнцагаан	9	820	80	900
	Нийт	13	2,500	80	2,580

Сонгуулийн үед Ковид-19 цар тахлын тусгаарлалтад байгаа иргэдээс битүүмжилсэн саналын хайрцгаар санал авч, тусгаарлалтад орсон сонгуулийн хэсгийн хорооны гишүүдийн оронд 4 сумын 13 иргэн нөхөн томилогдон ажиллаж, урамшуулал болон хоолны зардалд нэмж 2.6 сая төгрөгийг зарцуулсан байна. /Хүснэгт 3/ Дээрх 2.6 сая төгрөг нь төлөвлөгдөөгүй зардал бөгөөд СЕХ-ноос нэмэлтээр 1.3 сая

төгрөгийн санхүүжилтийг авч, 1.3 сая төгрөгийг эдийн засгийн ангилал хоорондын зохицуулалтаар шийдвэрлэсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдсан зардал

График 1 Зарцуулалт /хувиар/

Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдаж ирсэн нийт 50.7 сая төгрөгийн 64.2% буюу 32.6 сая төгрөгийг урамшууллын зардалд, 19.8% буюу 10.0 сая төгрөгийг сургалт зохион байгуулах зардалд, 6.2% буюу 3.2 сая төгрөгийг техник хэрэгсэл тээвэрлэх, хэвийн ажиллагааг хангах зардалд, 9.5% буюу 4.8 сая төгрөгийг бичиг хэрэг буюу сонгогчийн нэрсийн жагсаалт хэвлэх, хүргэх зардалд, 0.3% буюу 0.3 сая төгрөгийг



² Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

³ Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;

⁴ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална.

⁵ Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна;

⁶ Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

шуурхай багийн зардалд тус тус зарцуулсан байна. */График №1/*

Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2021 оны 05 сарын 15-ны өдрийн А/16 тоот тушаалаар 52 төрийн албан хаагчийг итгэмжлэгдсэн ажилтнаар томилсноос аймгийн 5 улсын бүртгэгч, сумын 14 улсын бүртгэгчийг ажиллуулж нийт 21.8 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Мөн УБЕГ-ын 2021 оны А/176 тоот “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтад “Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардлын төсөв”-ийг батлахдаа шуурхай багийн 3 ажилтан, аймгийн улсын бүртгэгч 12, нийт 15 ажилтанд 14.3 сая төгрөгийн урамшуулал олгохоор баталсан. Харин гүйцэтгэлээр шуурхай багт 8 ажилтан ажиллаж, урамшуулалд 3.6 сая төгрөгийг олгож, үлдсэн 3.5 сая төгрөгийг аймгийн улсын бүртгэлийн 12 ажилтан тус бүрд тэнцүү хуваан олгосон байна. Дээрх 12 ажилтан дотор аймаг болон сумын сонгуулийн хороонд давхар ажиллаж, цалин урамшуулал авсан 2 ажилтан байсан.

Дээрх байдлаас үзэхэд сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт бодитой хийгдээгүйгээс үлдэгдэл санхүүжилтийг буцаан төвлөрүүлэлгүй, бүгдийг нь зарцуулан, арвилан хэмнэлтгүй байдал гаргадаг нь харагдаж байна. */Хавсралт №5/*

Мөн аудитаар сургалт зохион байгуулах зардлаас албан томилолттой 43 албан хаагчдад 795.5 мянган төгрөгийн хоолны зардал давхардуулан олгосон зөрчил илэрсэн. Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2⁷, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2⁸ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд холбогдох албан тушаалтанд зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Цагдаагийн газар

Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын төсөвт хоолны зардал 8.8 сая төгрөг, шуудан холбооны зардал 2.0 сая төгрөг, шатахууны зардал 1.0 сая төгрөг, нийт 11.8 сая төгрөгийг Цагдаагийн газрын нярвын дансанд байршуулж бэлнээр зарцуулсан байна.

⁷ Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;

⁸ Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал/



БҮЛЭГ 2. Сонгууль зохион байгуулах зардлыг журмын дагуу тайлагнаж, хяналт тавьж ажилласан байна.

2.1 Сонгуулийн зардлын бүртгэлийг журмын дагуу хөтөлж, тайлагнасан байна.

Аймгийн сонгуулийн хороо СЕХ-ны 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих, журам”-ын 4.4⁹-т заасан хугацаанд сонгуулийн зардлын тайланг СЕХ-нд хүргүүлсэн байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулах үеэр нийт 77 нэр төрлийн 1.8 сая төгрөгийн цаашид ашиглах боломжтой бараа материал, хөрөнгийг бэлтгэснээс 51 нэр төрлийн 1.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж, 26 нэр төрлийн 0.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд аваагүй шууд зарлагаар тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС 12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т /Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ./ заасныг зөрчсөн тул аудитын явцад залруулга хийлгэн холбогдох байгууллагад бүртгүүлээ. /Хавсралт № 4/

2.2 Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

СЕХ-ны 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/17 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих, журам”-ын 3.10¹⁰-т зааснаар аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хороодод СЕХ-оос ирүүлсэн чиглэлийн дагуу 4 удаа сонгуулийн хорооны захирамжаар арга, зүйн зөвлөмж, чиглэл өгч, цахимаар онлайн групп үүсгэн тухай бүр заавар, зөвлөгөө өгөн ажилласан байна.

Мөн Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг сумдаар сонгуулийн үйл ажиллагаатай танилцан, анхан шатны баримтын бүрдлийг шалгаж заавар, зөвлөгөө өгч ажилласан байна.

⁹ /Сум, дүүргийн сонгуулийн хорооны болон салбар комиссын дарга, нарийн бичгийн дарга нар 4.3-т заасан тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын дарга, нягтлан бодогч нар энэ журмын 4.3-т заасан тайланг нэгтгэн 4.2-т заасны дагуу нэгдсэн тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж Сонгуулийн Ерөнхий Хороонд тус тус хүлээлгэж өгнө./

¹⁰ /Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина./



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг журмын дагуу хуваарилж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Бүлэг 1. Сонгууль зохион байгуулах зардлыг хууль журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна.

- ✓ Сонгуулийн хороодод зардлын төсвийг журмын дагуу хуваарилсан байна.
- ✓ Сонгууль зохион байгуулах зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч хэмнэлтгүй зарцуулжээ.

Бүлэг 2. Сонгууль зохион байгуулах зардлыг журмын дагуу тайлагнаж, хяналт тавьж ажилласан байна.

- ✓ Сонгуулийн зардлын бүртгэлийг журмын дагуу хөтөлж, тайлагнасан байна.
- ✓ Хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.



Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

1. Сонгуулийн зардлын төсвийг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөн хуваарилж, сонгуулийн зардлыг нэгдсэн бодлогоор хангаж ажиллах талаар ҮАГ-аар дамжуулан холбогдох дээд шатны байгууллагад уламжилж байна.

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.ИХБАЯР

АУДИТОР

Д.ДОЛЖИНСҮРЭН

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ



Тайлан баталгаажуулсан тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дүгнэлт А/16

Мандуулал

Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын бийгууллагаас аудит хийх журам”-ын 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ ИЙ:

1. “Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУА-2021/36-11-ШТА-СА/-г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага, зовломж) –ийг хансралтаар баталсугай.
3. “Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн Сонгуулийн хөрөөт хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зохиомж, албан шаардлагын хөрөгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2021 оны 3 дугаар улиралд таниншуулахыг ихлэх аудитор /Д.Ихбаяр/-г үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Р.МӨНХТОГТОХ



0012019054

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторын 2021 оны 7 дугаар сарын
09 – ны өдрийн А/16 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулсан зардлын хуваарилалт,
зарцуулалт үр дүн”-д хийсэн аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт

№	Аудитаар илэрсэн асуудал /Зөрчлийн товч утга /	Зөрчлийн дүн	Үүнээс /мянган төгрөгөөр/			
			Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн
1	Зарцуулагдаагүй үлдэгдлийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилт /сумын онцгой комисс/-ын дансанд шилжүүлсэн /Говь-Угтаал/	192.3	192.3			
2	Тайланд санхүүжилтийг дутуу тайлагнасан. /Гурвансайхан, Дэлгэрцогт, Луус/	2,595.9	2,595.9			
3	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардлыг хэтрүүлэн зарцуулсан. /Дэлгэрцогт, Хулд/	61.0	61.0			
4	Төлбөрийн цахим баримтаар гүйлгээ хийгээгүй. /Өлзийт/	1,922.2	1,922.2			
5	Хангамжийн материалыг шууд зарлагдсан /Өлзийт/	120.0	120.0			
6	Үр дүнгийн тайланд зардал дутуу тайлагнасан /Сайнцагаан/	927.7	927.7			
7	Бараа материалын тодруулга тайланд төсөвт байгууллагад шилжүүлсэн бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан. /Сайнцагаан/	225.0	225.0			
8	Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэг шилжүүлгийг тохируулах бичилт хийлгүй тайлагнасан. /Сайнцагаан/	927.7	927.7			
9	Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийг нэр төрлөөр тайлагнаагүй. /Сайнцагаан/	60,545.8	60,545.8			
10	Харилцах дансны үлдэгдэл төвлөрүүлснийг санхүүжилтээс хасаж тайлагнасан. /Хулд/	650.0	650.0			
11	Сурталчилгааны зардлын мөнгийг хэсгийн хорооны гишүүдэд утасны нэгж болгон өгсөн. /Цагаандэлгэр/	50.0	50.0			
12	Цаашид ашиглагдах боломжтой хангамжийн материал, хөрөнгийг бүртгэлд аваагүй /Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Цагаандэлгэр, Эрдэнэдалай/	559.0	559.0			
13	Улсын бүртгэлийн хэлтсийн сонгуулийн сургалт зохион байгуулах зардлаас албан томилолттой 43 албан хаагчдад 795.5 мянган төгрөгийн хоолны зардал давхардуулан гаргасан. /Улсын бүртгэлийн хэлтэс/	795.5			795.5	
Дүн		69,572.1	68,776.6	-	795.5	-

Хавсралт 1

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН АЙМАГ СУМЫН ХЭСГИЙН ХОРООНД
АЖИЛЛАСАН АЖИЛЧДЫН СУДАЛГАА**

№	Сумдын нэр	Салбар хороо				Хэсгийн хороо			МТБ	Бүгд /5 ороогүй /
		Салбар хорооны дарга	Салбар хорооны нарийн бичгийн дарга	Салбар хорооны гишүүд	Гэрээт	Хэсгийн хорооны тоо	Дарга	Гишүүд	Даамлын багийн гишүүд	
		1	2	3	4	5	6	7	8	
1	Адаацаг сум	1	1	3		5	5	40	6	56
2	Баянжаргалан	1	1	3		1	1	8	2	16
3	Говь-Угтаал	1	1	3		1	1	8	2	16
4	Гурвансайхан	1	1	3		2	2	16	3	26
5	Дэлгэрхангай	1	1	3		4	4	32	5	46
6	Дэлгэрцогт	1	1	3		3	3	24	4	36
7	Дэрэн	1	1	3		2	2	16	3	26
8	Луус	1	1	3		3	3	24	4	36
9	Өлзийт	1	1	3		3	3	24	4	20
10	Өндөршил	1	1	3		3	3	24	4	36
11	Сайхан-Овоо	1	1	3		4	4	32	5	46
12	Сайнцагаан	1	1	5		9	9	72	11	99
13	Хулд	1	1	3		4	4	32	5	46
14	Цагаандэлгэр	1	1	3		1	1	8	2	16
15	Эрдэнэдалай	1	1	5		7	7	56	8	78
16	АСХороо	1	1	7	2				5	16
		16	16	56	2	52	52	416	73	631

Хавсралт 2

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ХУВААРЬ

/сая төгрөг/

№	Нэрс	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	Бичиг хэргийн зардал	Шуудан, холбооны зардал	Унааны зардал /3500 км*500 /	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	МТБ, даамлын сургалтын зардал	Сурталчилгааны зардал	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	САС ашиглахтай холбоотой гарах зардал	Томилолтын зардал	Мэдээ дамжуулах унааны зардал	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	Болзошгүй зардал	Сумын сонгуулийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	Сумын хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	Даамлын урамшуулал, хоолны зардал	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	Нийт дүн
1	АСХороо	0.3	1.0	1.0	1.8	-	0.1	2.4	4.8	-	2.9	1.0	-	0.5	8.3	-	2.5	4.1	2.0	32.6
2	Сайнцагаан	-	1.2	1.5	4.9	2.3	0.2	0.5	0.4	0.4	0.2	-	0.6	1.7	3.5	38.1	5.2	-	-	60.5
3	Адаацаг	-	0.8	0.9	2.9	1.3	0.8	0.3	0.8	0.2	0.3	0.2	0.3	1.0	2.5	21.2	2.8	-	-	36.0
4	Баянжаргалан	-	0.3	0.3	0.9	0.3	0.4	0.1	0.6	0.0	0.3	-	0.1	0.2	2.5	4.2	0.9	-	-	10.9
5	Говь-Угтаал	-	0.3	0.3	0.9	0.3	0.4	0.1	0.6	0.0	0.3	-	0.1	0.2	2.5	4.2	0.9	-	-	10.9
6	Гурвансайхан	-	0.4	0.5	1.4	0.5	0.5	0.1	0.7	0.1	0.3	-	0.1	0.4	2.5	8.5	1.4	-	-	17.1
7	Дэлгэрхангай	-	0.6	0.8	2.4	1.0	0.7	0.2	0.8	0.2	0.3	-	0.3	0.8	2.5	16.9	2.4	-	-	29.6
8	Дэлгэрцогт	-	0.5	0.6	1.9	0.8	0.6	0.2	0.7	0.1	0.3	-	0.2	0.6	2.5	12.7	1.9	-	-	23.4
9	Дэрэн	-	0.4	0.5	1.4	0.5	0.5	0.1	0.7	0.1	0.3	-	0.1	0.4	2.5	8.5	1.4	-	-	17.1
10	Луус	-	0.5	0.6	1.9	0.8	0.6	0.2	0.7	0.1	0.3	-	0.2	0.6	2.5	12.7	1.9	-	-	23.4
11	Өлзийт	-	0.5	0.6	1.9	0.8	0.6	0.2	0.7	0.1	0.3	0.1	0.2	0.6	2.5	12.7	1.9	-	-	23.4
12	Өндөршил	-	0.5	0.6	1.9	0.8	0.6	0.2	0.7	0.1	0.3	-	0.2	0.6	2.5	12.7	1.9	-	-	23.4
13	Сайхан-Овоо	-	0.6	0.8	2.4	1.0	0.7	0.2	0.8	0.2	0.3	0.1	0.3	0.8	2.5	16.9	2.4	-	-	29.6
14	Хулд	-	0.6	0.8	2.4	1.0	0.7	0.2	0.8	0.2	0.3	-	0.3	0.8	2.5	16.9	2.4	-	-	29.6
15	Цагаандэлгэр	-	0.3	0.3	0.9	0.3	0.4	0.1	0.6	0.0	0.3	-	0.1	0.2	2.5	4.2	0.9	-	-	10.9
16	Эрдэнэдалай	-	1.0	1.2	3.9	1.8	1.0	0.4	0.9	0.3	0.3	0.3	0.5	1.3	3.5	29.6	3.8	-	-	49.5
Дүн		0.3	9.6	11.1	33.0	13.3	8.1	5.0	15.1	2.3	6.5	1.6	3.4	10.5	47.8	220.0	34.5	4.1	2.0	428

Хавсралт 3

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТӨСВИЙН ЗАРДЛЫН НЭГТГЭЛ /сая төгрөг/

№	Нэрс	Зардлын төрөл																Нийт дүн
		Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	Бичиг хэргийн зардал	Шуудан, холбооны зардал	Унааны зардал /3500 км*500/	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	МТБ, даамлын сургалтын зардал	Сурталчилгааны зардал	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, буцаан хүргэх зардал	САС ашиглахтай холбоотой гарах зардал /Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	Томилолтын зардал	Мэдээ дамжуулах унааны зардал	Болзошгүй зардал	Сумын сонгуулийн хороо, хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	Даамлын урамшуулал, хоолны зардал	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	
	Төлөвлөгөө	0.3	9.6	11.1	33.0	16.6	8.1	5.0	15.1	2.3	6.5	1.6	10.5	267.7	34.5	4.1	2.0	428
1	Аймгийн СХороо	0.0	0.7	1.0	1.7	-	-	2.4	4.2	-	1.9	-	0.5	8.3	2.5	3.9	1.9	29
2	Эрдэнэдалай	-	1.0	1.2	3.9	2.2	-	0.4	0.9	0.3	0.3	0.3	1.3	33.1	3.8	-	-	49
3	Цагаан-дэлгэр	-	0.3	0.3	0.8	0.3	-	-	0.6	0.0	0.2	-	0.2	6.7	0.9	-	-	11
4	Хулд	-	0.6	0.8	2.4	1.2	-	0.2	0.8	0.2	0.3	-	0.8	19.4	2.4	-	-	29
5	Сайхан-Овоо	-	0.6	0.8	2.4	1.3	-	0.2	0.8	0.2	0.3	0.1	0.8	19.4	2.4	-	-	29
6	Өндөршил	-	0.5	0.6	1.9	1.0	-	0.2	0.7	0.1	0.3	-	0.6	15.2	1.9	-	-	23
7	Өлзийт	-	0.5	0.6	1.8	1.0	-	0.2	0.7	0.1	0.3	0.1	0.6	15.2	1.9	-	-	
8	Луус	-	0.5	0.6	1.9	1.0	-	0.2	0.5	0.1	0.2	-	0.4	15.2	1.9	-	-	22
9	Дэрэн	-	0.4	0.5	1.4	0.6	-	0.1	0.7	0.1	0.3	-	0.4	11.0	1.4	-	-	17
10	Дэлгэрцогт	-	0.5	0.6	1.9	1.0	-	0.2	0.5	0.1	0.3	-	0.2	15.2	1.9	-	-	22
11	Дэлгэрхангай	-	0.6	0.8	2.4	1.3	-	0.2	0.4	0.2	0.2	-	0.8	19.3	2.4	-	-	28
12	Гурвансайхан	-	0.4	0.5	1.4	0.6	-	0.1	0.7	0.1	0.3	-	0.4	11.0	1.4	-	-	17
13	Говь-Угтаал	-	0.3	0.3	0.9	0.3	-	0.1	0.6	0.0	0.3	-	-	6.7	0.9	-	-	10
14	Баянжаргалан	-	0.3	0.3	0.9	0.3	-	0.1	0.6	0.0	0.3	-	0.2	6.7	0.9	-	-	11
15	Адаацаг	-	0.8	0.9	2.9	1.6	-	0.3	0.7	0.2	0.3	0.2	1.0	23.7	2.8	-	-	35

16	Сайнцагаан	-	1.2	1.5	4.9	2.9	-	0.5	0.3	0.4	-	-	1.3	41.6	5.2	-	-	60
	Нийт зардал	0.0	9.3	11.0	32.9	16.6	-	5.0	13.4	2.4	5.3	0.6	9.3	267.6	34.5	3.9	1.9	413.6
	Хэтрэлт, хэмнэлт	0.2	0.3	0.0	0.1	0.1	8.1	0.1	1.7	(0.1)	1.2	1.0	1.2	0.1	-	0.2	0.1	14.4

Хавсралт 4

МУЕС-ЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛААС ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГАД ОРЛОГОДОЖ БҮРТГЭЛД АВСАН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Бүртгэлд авсан хөрөнгө /Мянган төгрөг/					Бүртгэлгүй хөрөнгө /Мянган төгрөг/				
	Сумын нэр	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Сумын нэр	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1					-	Адаацаг	Төрийн далбаа	5	40.0	200.0
2					-	Адаацаг	Тооны машин	1	24.5	24.5
3	Баянжаргалан	Уртасгагч	1	24.0	24.0					-
4	Баянжаргалан	Уртасгагч	1	24.0	24.0					-
5	Говь-Угтаал	Самбар	2	24.4	48.8					-
6	Говь-Угтаал	Далбаа	2	25.0	50.0					-
7	Дэлгэрхангай	Далбаа	8	20.0	160.0					
8	Дэлгэрцогт	Ус буцалгагч	1	55.0	55.0					-
9	Дэлгэрцогт	Далбаа	3	28.0	84.0	Дэлгэрцогт	Тугны суурь	3	12.0	36.0
10	Дэрэн	төрийн далбаа	1	30.0	30.0	Дэрэн	хогийн шүүр	1	9.0	9.0
11	Дэрэн	төрийн далбаа	2	25.0	50.0	Дэрэн	хогийн сав	1	24.0	24.0
12	Дэрэн	цаг	1	28.0	28.0	Дэрэн	цоож	1	3.5	3.5
13	Дэрэн	самбар	2	19.8	39.6	Дэрэн	цоож	1	5.0	5.0
14	Дэрэн	галын хор	1	50.0	50.0	Дэрэн	уртасгагч	1	20.0	20.0
15					-	Луус	флаш	1	25.0	25.0
16	Өндөршил	Галын хор	1	35.0	35.0					-
17	Өндөршил	Нүүрний хаалт	10	3.0	30.0					-
18	Өндөршил	Утаа мэдрэгч	1	30.0	30.0					-
19	Өндөршил	Халуун хэмжигч	1	65.0	65.0					-
20	Өндөршил	Төрийн далбаа	2	15.0	30.0					-
21	Хулд	Далбаа	4	28.0	112.0					
22						Цагаандэлгэр	Санал өгөх бүхээг	3	30.0	90.0
23						Цагаандэлгэр	Далбаа	1	40.0	40.0
24	Эрдэнэдалай	Далбаа	7	40.0	280.0	Эрдэнэдалай	Уртасгагч	1	20.0	20.0

25					-	Эрдэнэдалай	Хогийн шүүр, хутгуур	1	15.0	15.0
26					-	Эрдэнэдалай	Гар чийдэн	1	10.0	10.0
27					-	Эрдэнэдалай	Цаг	1	25.0	25.0
28					-	Эрдэнэдалай	Гар чийдэн	3	4.0	12.0
	-	-	51	569.2	1,225.4	-	-	26	307.0	559.0

Хавсралт №5

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ СОНГУУЛИАР УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН АЖИЛТНУУДАД ОЛГОСОН УРАМШУУЛАЛ

/Мянган төгрөг/

№	Албан тушаал	Аймаг/сум	Улсын бүртгэгч			
			Орон тоо	Итгэмжлэгдсэн ажилтан	Шуурхай баг	Урамшуулал
1	Улсын ахлах бүртгэгч	Аймаг	1		420.0	293.0
2	Нягтлан бодогч	Аймаг	1		420.0	293.0
3	МТ ажилтан	Аймаг	1		420.0	293.0
4	Нярав	Аймаг	1		420.0	293.0
5	архивч	Аймаг	1		420.0	293.0
6	Хяналтын байцаагч	Аймаг	1		420.0	293.0
7	Гэрээт	Аймаг	1		420.0	293.0
8	архивч	Аймаг	1		420.0	
9	Ахлах бүртгэгч	Аймаг	1			293.0
10	Улсын бүртгэгч	Адаацаг	1	420.0		
11	Улсын бүртгэгч	Баянжаргалан	1	420.0		
12	Улсын бүртгэгч	Говь-Угтаал	1	420.0		
13	Улсын бүртгэгч	Гурвансайхан	1	420.0		
14	Улсын бүртгэгч	Дэлгэрхангай	1	420.0		
15	Улсын бүртгэгч	Дэлгэрцогт	1	420.0		
16	Улсын бүртгэгч	Дэрэн	1	420.0		
17	Улсын бүртгэгч	Луус	1	420.0		
18	Улсын бүртгэгч	Өлзийт	1	420.0		
19	Улсын бүртгэгч	Өндөршил	1	420.0		
20	Улсын бүртгэгч	Сайхан-Овоо	1	420.0		
21	Улсын бүртгэгч	Хулд	1	420.0		
22	Улсын бүртгэгч	Цагаандэлгэр	1	420.0		
23	Улсын бүртгэгч	Эрдэнэдалай	1	420.0		
24	Улсын бүртгэгч	Сайнцагаан	1	420.0		
25	Улсын бүртгэгч	Сайнцагаан - УБХ	4	1,680.0		1,172.1
Нийт дүн			28	7,980.0	3,360.0	3,516.2

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn 